




Нийт 26 багш ажилтантай. Нэг дүгээр цэцэрлэг нь хамран сургах тойргийн 2,3,4 дүгээр багийн 210 хүүхдийг танхимын 7 бүлэг ээлжийн нэг бүлгээр авч 2023-2024 оны хичээлийн жилийн үйл ажиллагааг явуулж байна.

"ХУЖИРТ СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ"-ИЙН ХАМТ ОЛОН БАГШИЙН БОЛОН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНД АМЖИЛТТАЙ ҮНЭЛЭГДЛЭЭ

Аймгийн тэргүүний 1 дүгээр цэцэрлэгийн хамт олон бид Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд сургалтын байгууллагын үр дүнд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээний 6-н шалгуур үзүүлэлтээр 2022 онд ажлаа дүгнүүлж 4 дүгээр түвшинд амжилттай үнэлэгдлэж байсан бол 2023 онд амжилтаа ахиулан Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд БШУС-ын 2022 оны А/500 тоот тушаалын дагуу ЕБС, Цэцэрлэгийн үйл ажиллагааны чанар, сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнг шалгах 6-н шалгуур үзүүлэлтээр ажлаа дүгнүүлж эрэмбэлэгдэхэд индексийн түвшин 2 ДУГААР ТҮВШИН-д үнэлэгдсэн, 2022 онд сумын Боловсролын салбарын 5 байгууллагаасаа ганцаараа гүйцэтгэлийн үнэлгээнд амжилттай үнэлэгдэж урамшуулал авсан.



Хүүхдийн хөгжлийн ахиц

№	Багш	Хөгжлийн чиглэл (Гүйцэтгэл)					
		Бие бялдар		Таних мэдэхүй		Нийгэмшүүр	
		2022	2023	2022	2023	2022	2023
1.	БАЯРСАЙХАН НАРАНГЭРЭЛ	69	96.43	65	87	98	50
2.	ДАМДИНЖАВ АЮУРЗАНА	89.17	83.33	85	95	98	100
3.	ДЭЛГЭРМАА ДЭМБЭРЭЛСЭРЭЭНЭН	84.62	100	75	87	83	96
4.	ЗОЛЗАЯА ГАНБОДЬ	62.14	100	64	91	92	85
5.	НЯМХАНД БЯМБА	93.33	100	88	96	91	94
6.	ОТГОНБАТ САМДАН	96.92	100	89	97	80	95
7.	САРАНЦЭЦЭГ АЮУШ	91.67	100	90	97	93	93
8.	УУГАНБААТАР АЛТАНГЭРЭЛ			76			

Байгууллага, багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд амжилттай хамрагдсанаар төсвөөс гадна нэмэлт урамшууллыг хүүхдийн тооноос хамаарч олгодог журамтай. Энэ жилийн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаараа манай менежментийн баг шинэ сургалтын хөтөлбөрийг 4.422.000 төгрөгөөр худалдан авч хэрэгжүүлэхээр бэлэн боллоо. Энэхүү хөтөлбөрийг Өвөрхангай аймагтаа хэрэгжүүлж байгаа анхны хэрэглэгч нь таны, манай хүүхдүүд байгаад баяртай байна. "AR" /Augmented Reality/ дэвшилтэт технологиор баяжуулсан цахим сургалтын хэрэглэгдэхүүнийг бага насны хүүхдийн танин мэдэхүйн онцлогт тохируулан бодит мэт виртуал өгөгдлөөр баяжуулсан дижитал контент, аудио, видео, 3D харагдуулдаг хэрэглэгдэхүүнийг сургалт, үйл ажиллагаандаа нэвтрүүлээ. МОНГОЛ АХУЙ, НАРНЫ АЙМАГ "AR" ХАНЫН ЗУРАГ тус бүрдээ 2D анимейшн болон аудио хэлбэрээр баяжуулсан 62 төрлийн сонирхолтой агуулгаар Монгол ахуй соёлыг болон Нарны аймгуудыг ТАНЫ ХҮҮХДЭД бүрэн таниулах болно.

- ✓ "ШИДЭТ ҮЛГЭРҮҮД" Үлгэрийн баатрууд 3D хэмжээст дүрслэлээр гарч ирнэ. Үлгэрээ сонсоно уншина, хүүхэдэйн киног номноос үзнэ.
- ✓ "ШИДЭТ ЭВЛҮҮЛДЭГ PUZZLE" Puzzle тоглоомыг эвлүүлж дууссанаар эвлүүлсэн дүрс амилж таны хүүхэдтэй ярилцаж тоглох болно.
- ✓ ШИДЭТ БУДДАГ НОМ, ШИДЭТ ӨНГӨ, ДҮРС, ШИДЭТ ТОО, ТАРААХ МАТЕРИАЛ бүхий хэрэглэгдэхүүнээр дамжуулан ТОГЛОНГОО СУРАЛЦАХ боломжтой болсноос гадна танай гэр бүл гэртээ ямар ч интэрнэт, датагүй орчинд ч үзэж хөгжих боломжийг нээж өгсөнөөрөө баяртай байна.



AR Mongolia сургалтын хэрэглэгдэхүүнийг түгээн дэлгэрүүлэх ажил явагдсаар. Аймгийн Боловсролын газрын удирдлага, мэргэжилтэнгүүд, СӨБ-ын удирдлагууд, Орхон түшээ бүсийн СӨБ-ын байгууллагуудын удирдлагууд болон багш нар, Хужирт сумын ЕБС-ын Бага ангийн ЗАН, Майнцэцэг, Амаржаргал багштай 3-р ангийн сурагчид, Сумын Засаг дарга Д. Батбаяр, Бичиг хэргийн эрхлэгч Цэвээндулам, Тамгын газрын дарга З. Цэцэгмаа, ИХ-ын төлөөлөгч Оюунцэцэг, Цэцэрлэгийн нийт эцэг эхчүүдэд танилцуулах ажлыг зохион байгууллаа



Мөн 13 хайрцаг цэцэрлэгийн хүүхдийн багц паззлаа оноос өмнө авсан. Эвлүүлж тоглоонгоо шинэ мэдлэг олж авч 13 хайрцаг паззлд 400 гаруй агуулга багтсан байгаа.



ХУЖИРТ СУМЫН ХҮҮХДИЙН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ОНЦЛОХ АЖЛУУД

1. Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтод жилийн хүрээнд:


Хоол үйлдвэрлэлийг дэмжих жил"-ийн хүрээнд хоолны үзэсгэлэн гаргасан.



2. 2023 оны 08 дугаар сарын 30ны өдөр Хархорин суманд зохион явагдсан Солонгос хоолны сургалтад Эрхлэгч тогооч туслах багш нар хамрагдсан. Зориулалтын бус хүнсний савыг хэрэглээнээс гаргасан.



3. Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд сургалтын байгууллагын үр дүнд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээний 6 шалгуур үзүүлэлтээр 2022 онд ажлаа дүгнүүлж 4 дүгээр түвшинд амжилттай үнэлэгдэж байсан бол 2023 онд амжилтаа ахиулан Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд БШУС-ын 2022 оны А/500 тоот тушаалын дагуу ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагааны чанар, сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнг шалгах 6 шалгуур үзүүлэлтээр ажлаа дүгнүүлж эрэмбэлэгдэхэд индексийн түвшин 2 дугаар түвшинд үнэлэгдсэн ахицтай. Хүний нөөцийн ассициасийн 1500 асуумжаар үнэлгээ хийлгэсэн. Үнэлгээний үр дүнд суурилан модуль сургалтыг албан хаагчдад зохион байгуулахаар төлөвлөөд байна.



4. 2023-2024 оны хичээлийн жилд манай байгууллага нийт 26 албан хаагчидтай үйл ажиллагаагаа явуулж байна. Хамран сургах тойргийн 5 настай 55 хүүхдийг бүрэн 100% танхимын сургалтаар хамруулсан. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ хийхэд 57 хүүхэд 94 хувьтай шалгагдлаа. Бат-Өлзий1,2 Хужирт сумын 2,3,4 дүгээр цэцэрлэгтэй багш, туслах багш солилцоог амжилттай явуулсан.



5. Биеийн тамир спорт, дасгал хөдөлгөөнийг албан хаагчдад болон хүүхдүүдэд тогтмол хийлгэж хэвшсэн. Аймгийн хэмжээний биеийн тамир спортын шилдэг байгууллага Алтан цомын эзэн болсон.



6. Сумын хэмжээний “Миний нандин”, “Амар байна уу” аянуудад амжилттай оролцон Сумын соёлын төвийн шилдэг байгууллага өргөмжлөлөөр шагнагдсан. Өвөрхангай аймгаас жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Миний өвөрхангай” аянд амжилттай оролцон Тусгай байрт шалгарсан. Нэг ном эрхэм үйлс аянд амжилттай оролцон “Оюунлаг байгууллагаар” шалгарсан



7. Сумын СӨББ-ын хэмжээнд зохион байгуулагдсан “Ногоон гэрэл цагаан шугам” тэмцээнд 2 баг оролцон Дэд, гутгаар байр эзэлсэн.



8. Замын хөдөлгөөн үйл ажиллагааны хүрээнд байгууллагын урд болон хойд талбайд авто машины зогсоол хийж тэмдэгжүүлсэн.



9. Оны оцлох залуучуудыг алдаршуулан шалгаруулдаг Алтан сарнай 2023 оны Боловсрол нийгмийн салбарын шилдэг залуугаар Дунд “Б” бүлгийн багш Ганбодийн Золзаяа шалгарсан.

